



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 29 өдөр

Дугаар A/289

Булган сум

### Гүйцэтгэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны XIX/08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн

**ЗАХИРАМЖЛАХ нь:**

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан Аймгийн Засаг даргын Тамгын газрын төвлөрсөн арга хэмжээнд ашиглагдах сандал нийлүүлэх нийлүүлэгчээр шалгарсан “Гантэлмэн” ХХК-тай 43,890,000 (Дөчин гурван сая найман зуун зуун ерэн мянган) төгрөгөөр гэрээ байгуулахыг Булган аймгийн Засаг даргын Тамгын газрын Тамгын дарга (Д.Алтаншагай)-д үүрэг болгосугай.

2. Ажлын гүйцэтгэлд холбогдох хууль, тогтоомж, гэрээний дагуу хяналт тавьж, хүлээн авахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (М.Батчимэг)-д үүрэг болгосугай:

3. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандарт, техникийн тодорхойлолтын дагуу нийлүүлэх, хүлээлгэн өгөхийг “Гантэлмэн” ХХК-ийн Гүйцэтгэх захирал (Б.Будсүрэн)-д үүрэг болгосугай.

4. Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Батцогт)-д зөвшөөрсүгэй.

5. Хөрөнгийг данс бүртгэлд тусгаж ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг Нийтлэг үйлчилгээний албаны дарга (Х.Энхбаатар)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Б.АРИУН-ЭРДЭНЭ

Sugar Ajkil 2024 өдөр бүр Doc/2024/Захирамж

6324010382

Аймгийн Засаг даргын 2024 оны  
01 дүгээр сарын 29-ний өдрийн 28.9. дугаар  
захирамжийн хавсралт

Д/д	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	2	3	4
1	Алданги	Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна	Д.Батцогт
2	Баталгаат хугацаа	1 жил	Д.Алтаншагай